



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/1986

Мандалговь

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг эрүүл мэндийн салбарт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Н.Дэлгэрмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)  
П.Нямсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)  
И.Тогооч (Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч)  
Б.Мөнхчулуун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)  
Д.Ганчимэг (Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга: Э.Цэвэлмаа (Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг эрүүл мэндийн салбарт 2022 оны 06 сарын 27-ны өдрөөс 10 сарын 01-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111015